

**МОНГОЛ УЛСЫН ОДОН МЕДАЛИАР ШАГНУУЛАХААР  
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН АЖИЛТНЫ АНКЕТ**



- |                                  |   |
|----------------------------------|---|
| <b>1. Овог нэр</b>               | Хэнмэдхэв   |
| <b>2. Нэр</b>                    | Цэнд-Аюуш   |
| <b>3. Төрсөн огноо</b>           | 1974.01.15  |
| <b>4. Хүйс</b>                   | Эрэгтэй   |
| <b>5. Төрсөн аймаг, сум, хот</b> | Өвөрхангай аймаг Уянга сум  |
| <b>6. Одоогийн харьяалал</b>     | Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг  |
| <b>7. Нийгмийн байдал</b>        | Сэхээтэн  |
| <b>8. Регистр</b>                | ЙО74011514  |
| <b>9. Боловсрол</b>              | Дээд  |
| <b>10. Ажилладаг салбар</b>      | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт,<br>шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар |
| <b>11. Мэргэжил</b>              | Нягтлан бодогч-эдийн засагч   |

**12. Урьд болон одоо ажиллаж байгаа газар**

Д/д	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1	Өвөрхангай амгийн Уянга сумын 10 жилийн сургууль	1995-1997	Нягтлан бодогч
2	Өвөрхангай аймгийн Уянга сумын Ядуурлыг бууруулах зөвлөл	1997-1998	Нарийн бичгийн дарга
3	Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс	1998-2002	Байцаагч, Ахлах байцаагч
4	Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс	2002-2007	Хяналт шалгалтын тасгийн дарга
5	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	2010-2014	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч
6	Уул уурхайн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар	2014 оны 11 сараас	Мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч
7	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар	2019 оны 11 сараас	Газрын ахлах мэргэжилтэн
8	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар	2020 оны 09 сараас	Ахлах шинжээч

### 13. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

Д/д	Шагналын нэр	Хэдэн онд
1	Монголын Залуучуудын Холбооны "Тэргүүний залуу" алтан медаль	2002 он
2	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны "Хүндэт жуух бичиг"	2006 он
3	"Санхүү банкны тэргүүний ажилтан"-цол тэмдэг	2015 он
4	Хөдөлмөрийн хүндэт медаль	2015 он

### 14. Шагнуулах үндэслэл:

Х.Цэнд-Аюуш ажиллах хугацаандаа санхүү бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад гол анхаарлаа хандуулан, шалгалтанд хамрагдсан байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнууд болон холбогдох ажил хариуцаж буй албан тушаалтанд шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын шалтгааныг ойлгуулж цаашид дахин давтан гаргуулахгүй байх талаас нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн шалтгааныг тодруулах, тогтоогдсон төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэхэд ажлаа чиглүүлэн ажиллаж байна.

Х.Цэнд-Аюуш нь Нийгмийн даатгалын улсын ахлах байцаагч болон Санхүүгийн хяналтын улсын байцаагчаар ажиллах хугацаандаа 257 байгууллагад санхүүгийн баримтын шалгалт хийж, 62.7 сая төгрөгийн алданги торгууль, 1778.7 сая төгрөгийн нөхөн төлбөр илрүүлж, тогтоосон төлбөр, торгууль, алдангийг бүрэн барагдуулах талаар санаачлагатай үр бүтээлтэй ажилласан мөн байгууллагын нэгдсэн тайлан, бодлогын баримт бичгүүдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэлгээ хийж, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Х.Цэнд-Аюуш нь төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагад 27 жил тогтвортой, үр бүтээлтэй ажилласныг үнэлэн "Алтан гадас" одонгоор шагнуулахаар тодорхойлов.

### 15. Нэр дэвшүүлж байгаа шагналын нэр:

"Алтан гадас" одон

### 16. Хамт олны саналын хувь: 100 %

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ

УУХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын  
хурлын тэмдэглэл

2021.09.24

Улаанбаатар хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ээлжит хурлыг 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 11 цагт зохион байгуулсан бөгөөд хурлыг газрын дарга Ц.Одхүү удирдан, хэлтсийн дарга Т.Баасанпүрэв, ахлах шинжээч Х.Цэнд-Аюуш, шинжээч Н.Цогтбаяр (цахимаар), ахлах мэргэжилтэн Д.Батнайрамдал, ахлах мэргэжилтэн Х.Наран-Эрдэнэ (цахимаар), мэргэжилтэн Ж.Энхсайхан, мэргэжилтэн Б.Түмэннаст (цахимаар) нар оролцов.

**ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:**

Монгол Улсад Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 99 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын хууль тогтоомж болон төрөөс уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт баримтлах бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн ажлын үр дүнг нь үндэслэн УУХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдыг төрийн одон, медалиар шагнуулахаар тодорхойлох асуудлыг хэлэлцэв.

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

Ц.Одхүү: Монгол Улсад Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 99 жилийн ой 12 дугаар сарын 25-ны өдөр тохионо. Энэ хүрээнд гүйцэтгэсэн ажлын үр дүнг нь үндэслэн манай газраас төрийн одон, медалиар шагнуулахаар тодорхойлох албан хаагчдын асуудлыг хэлэлцэе. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Х.Наран-Эрдэнэ: Би Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Т.Баасанпүрэвийг “Алтан гадас” одонгоор шагнуулахаар тодорхойлох саналтай байна. Т.Баасанпүрэв нь улсад, тэр дундаа уул уурхайн салбарт 20 жил ажилласан туршлагатай.

Н.Цогтбаяр: Уг саналыг дэмжиж байна.

Ж.Энхсайхан: Дэмжиж байна. Мөн улсад 15 дахь жилдээ, үүнээс геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 7 дахь жилдээ үр бүтээлтэй ажиллаж байгаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч Н.Цогтбаярыг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулахаар тодорхойлох саналтай байна.

Б.Түмэннаст: Би Х.Наран-Эрдэнэ, Ж.Энхсайхан нарын саналыг дэмжиж байна.

Х.Цэнд-Аюуш: Саналуудыг дэмжиж байна.

Д.Батнайрамдал: Дээрх саналуудыг дэмжинэ. Миний зүгээс Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч Х.Цэнд-Аюушыг “Алтан гадас” одонгоор шагнуулахаар тодорхойлох саналтай

байна. Х.Цэнд-Аюуш нь улсад 27 дахь жилдээ, үүнээс төрийн албанд 26 дахь жилдээ үр бүтээлтэй ажиллаж байгаа.

Т.Баасанпүрэв: Саналуудыг бүрэн дэмжиж байна.

Ц.Одхүү: За саналуудыг сонслоо. Өөр саналгүй бол Монгол Улсад Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 99 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын хууль тогтоомж болон төрөөс уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт баримтлах бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн ажлын үр дүнг нь үндэслэн хэлтсийн дарга Т.Баасанпүрэв, ахлах шинжээч Х.Цэнд-Аюуш нарыг “Алтан гадас” одонгоор, шинжээч Н.Цогтбаярыг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулахаар тодорхойлох гэдгээр саналаа хураая.

Хуралд оролцогчид Т.Баасанпүрэв, Х.Цэнд-Аюуш, Н.Цогтбаяр нарыг шагнуулах саналыг 100 хувь дэмжив.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

УУХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Хэлтсийн дарга Т.Баасанпүрэв, ахлах шинжээч Х.Цэнд-Аюуш нарыг “Алтан гадас” одонгоор, шинжээч Н.Цогтбаярыг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулах саналыг холбогдох газарт уламжлан хүргүүлэхээр тогтов.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ХШУДАГ-ын дарга

ЦБМТХ-ийн дарга

ХШУДАГ-ын ахлах шинжээч

ХШУДАГ-ын шинжээч

ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

ЦБМТХ-ийн ахлах мэргэжилтэн

ЦБМТХ-ийн мэргэжилтэн

Ц.Одхүү

Т.Баасанпүрэв

Х.Цэнд-Аюуш

Н.Цогтбаяр

Д.Батнайрамдал

Ж.Наран-Эрдэнэ

Б.Түмэннаст

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ХШУДАГ-ын мэргэжилтэн

*Н. Энхсайхан*

Ж.Энхсайхан

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ ХЭНМЭДХЭВ ОВОГТОЙ  
ЦЭНД-АЮУШИЙН АЖИЛ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

2021.09.27

Улаанбаатар хот

Х.Цэнд-Аюуш нь 1974 онд Өвөрхангай аймгийн Уянга суманд төрсөн. 1981 онд Монгол улсын ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн нэрэмжит 10 жилийн сургуульд орж суралцан 1991 онд төгсөж, улмаар 1991 онд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуульд суралцан 1995 онд бизнесийн удирдлага, эдийн засагч мэргэжлээр төгссөн.

Х.Цэнд-Аюуш нь улсад 27 дахь жилдээ ажиллаж байгаагийн 26 жилд нь төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, түүний дотор нийгмийн даатгал, санхүү, бүртгэл, хяналт шалгалтын байгууллагын системд ажиллаж байна.

Х.Цэнд-Аюуш нь нийгмийн даатгалын байгууллагад байцаагч, хяналт шалгалтын тасгийн даргаар ажиллахдаа хяналт шалгалтын ажлыг хууль эрх зүйн түвшинд чанартай хийх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын хуулинд өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллаж зохих үр дүнд хүрсэн. Мөн санхүүгийн хяналт шалгалтын ажлыг шуурхай хийж, улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөрийн хууль, эрх зүйн үндэслэлийг зөв тогтоож, тавигдсан актын төлбөрийг барагдуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээтэй холбоотой хууль, тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хүрээнд дүгнэлт өгч, зөвлөмжөөр хангахад онцгой анхаарч ажиллаж ирсэн.

Х.Цэнд-Аюуш нь 1998 оны 09 дүгээр сараас Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст байцаагч, ахлах байцаагч, хяналтын тасгийн даргаар ажиллаж байсан ба 2010 оноос хүртэл Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчаар 2014 оны 08 дугаар сарын 25-аас 10 дугаар сарын 01 хүртэл Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын хэлтсийн ахлах, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчаар ажилласан ба 2014 оны 11 дүгээр сараас Уул уурхайн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт мэргэжилтэн, 2020 оны 09 дүгээр сараас мөн газарт ахлах шинжээчээр ажиллаж байна.

Нийгмийн даатгалын байгууллагад 1998-2006 онд ажиллах хугацаандаа 180 гаруй төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, хувийн болон хувьцаат компанид нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг шалгаж, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод 815.9 сая

төгрөгийг нөхөн төлбөрөөр, улсын төсөвт 62.7 сая төгрөгийг алданги торгуулиар оруулж, төлбөр зөрчлийг хугацаанд нь барагдуулж ажилласан. Мөн санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчаар ажиллах хугацаандаа 77 төрийн өмчит болон төсөвт байгууллагад шалгалт хийж 1778.7 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлэн, хугацаанд нь барагдуулах, хяналт шинжилгээ, үнэлгээг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж дүгнэлт гарган, зөвлөмжөөр ханган ажилласан байна.

Х.Цэнд-Аюуш нь шалгалтыг удирдамжинд заасан хугацаанд нь чанартай хийх, бүртгэл тооцооны ажилтнуудад гаргасан зөрчил дутагдлыг ойлгуулах, дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх, шалгалтаар тогтоогдсон актын төлбөрийг барагдуулах, шалгалтын үр дүнг сурталчлах, шалгалтын нэгдсэн болон нэгбүрчилсэн акт, танилцуулгыг тухайн байгууллагын эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулан шинжилгээний үндсэн дээр хийх, түүнийг боловсронгуй болгох, хяналт, шинжилгээ үнэлгээтэй холбоотой хууль, тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хүрээнд дүгнэлт өгч, зөвлөмжөөр хангахад өөрийн хүч, оюуныг дайчлан ажиллаж ирсэн болно.

Х.Цэнд-Аюуш нь төрийн захиргааны албанд нийгмийн хамгаалал, санхүү, эдийн засаг, хяналт шалгалт, дотоод аудитын ажил хариуцан олон жил ажилласан, хүнтэй ажиллах арга зүйг эзэмшсэн, мэргэжлийн ур чадвар сайтай, аливаа ажилд хариуцлагатай ханддаг, хамт олондоо нэр хүндтэй ажилтан юм.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ